



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Үндсэн цалин, нэмэгдэл шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Их хурлын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоол, Монгол улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” 382 дугаар тогтоол, 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралт, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Газрын нийт албан хаагчдын 2022 оны үндсэн болон нэмэгдэл цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Шинэчлэн баталсан үндсэн болон нэмэгдэл цалин хөлсийг хууль, тогтоомжийн дагуу тооцож үндсэн цалингийн сангаас сар бүр олгож ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (О.Оджаргал)-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Т.ТӨМӨРДУЛАМ

